МҮХАҮТ

10-Р САРЫН ТОЙМ





БУСАД НҮҮРЭНД



КАРЕК–ийн Танхимуудын холбоог МҮХАҮТ 2026 онд даргална



Монголын компаниуд хүний эрхийн эрсдэлийг үнэлэх хэрэглэгдэхүүнтэй боллоо



МҮХАҮТ Сингапурын Meinhardt Group–ийн удирдлагуудтай уулзлаа



Хойд бүсийн бизнес, хөрөнгө оруулалтын чуулган боллоо



Бизнес эрхлэгчид шинэ үйлдвэртэй танилцлаа



Бизнес эрхлэгчдэд үзүүлэх дэмжлэгийн боломжуудыг хэлэлцлээ



Монгол, Сингапурын бизнесийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ



ISO/IEC 17025 стандартын сургалтад 21 мэргэжилтэн хамрагдлаа



Хойд бүсийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн уулзалт боллоо



Business Outlook 2027: Ирэх оны бизнесийн төлөвийг хэлэлцлээ



Шинэ гишүүддээ гэрчилгээ гардууллаа



Берлин, Хельсинки, Минск: Гурван улсад 95.5 сая ам.долларын хамтын ажиллагааны тохиролцоо хийлээ

10-Р САРЫН ТОЙМ

КАРЕК–ийн Танхимуудын холбоог МҮХАҮТ 2026 онд даргална





КАРЕК–ийн Танхимуудын холбооны анхдугаар уулзалтаар МҮХАҮТ–ыг 2026 онд холбоог даргалахаар тогтож, бүс нутгийн худалдаа, хөрөнгө оруулалт, логистикийн хамтын ажиллагааг өргөжүүлэхээр боллоо.

Монголын компаниуд хүний эрхийн эрсдэлийг үнэлэх хэрэглэгдэхүүнтэй боллоо



МҮХАҮТ Европын Холбооны SOCIEUX+ хөтөлбөрийн хүрээнд аж ахуйн нэгжүүдэд зориулсан хүний эрхийн магадлан шинжилгээний таван модуль бүхий хэрэглэгдэхүүн боловсруулаа.



Хойд бүсийн бизнес, хөрөнгө оруулалтын чуулган боллоо

Канадын сангийн дэмжлэгтэй зохион байгуулсан чуулганд Орхон, Булган, Хөвсгөл аймгийн 150 орчим бизнес эрхлэгч оролцож, бүс нутгийн бизнес, хөрөнгө оруулалтын боломжийг хэлэлцлээ.





Бизнес эрхлэгчдэд үзүүлэх дэмжлэгийн боломжуудыг хэлэлцлээ






Монгол, Сингапурын бизнес форумын үеэр МҮХАҮТ болон Сингапурын Бизнесийн Холбоо хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, худалдаа, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн боломжийг хэлэлцлээ.

ISO/IEC 17025 стандартын сургалтад 21 мэргэжилтэн хамрагдлаа



МҮХАҮТ–ын Итгэмжлэгдсэн лабораториудын зөвлөлөөс зохион байгуулсан хоёр өдрийн сургалтаар лабораторийн шинжилгээний аргын баталгаажуулалт, нотолгоо бүрдүүлэх практик ур чадварыг эзэмшүүллээ.

МҮХАҮТ–аас мэдэгдэл гаргалаа



Үндэсний үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн нэр хүндэд халдсан, баримтгүй мэдээлэлтэй холбогдуулан МҮХАҮТ–аас мэдэгдэл гаргаж, үйлдвэрлэгчдийг үндэслэлгүй буруутгалаас хамгаалах байр суурия илэрхийллээ.

МҮХАҮТ Сингапурын Meinhardt Group–ийн удирдлагуудтай уулзлаа





Уулзалтаар барилга, дэд бүтэц, хот төлөвлөлт, ус, байгаль орчин, төслийн менежментийн чиглэлээр хамтран ажиллах боломжийг хэлэлцлээ.

Бизнес эрхлэгчид шинэ үйлдвэртэй танилцлаа





Хойд бүсийн чуулганы хүрээнд Булган, Хөвсгөл аймгийн бизнес эрхлэгчид “Орхон Энхбүтэмж” ХХК–ийн шинэ үйлдвэртэй танилцаж, үйлдвэрлэлийн технологи, үйл ажиллагааны туршлагаас суралцлаа.

Монгол, Сингапурын бизнесийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ





МҮХАҮТ–ын Итгэмжлэгдсэн лабораториудын зөвлөлөөс зохион байгуулсан хоёр өдрийн сургалтаар лабораторийн шинжилгээний аргын баталгаажуулалт, нотолгоо бүрдүүлэх практик ур чадварыг эзэмшүүллээ.

MIU дээд сургуулийн багш, оюутнууд МҮХАҮТ–тай танилцлаа





МҮХАҮТ–ын Гүйцэтгэх захирал Ц.Магнайбаатар багш, оюутнуудад Танхимын үйл ажиллагаа, хувийн хэвшлийг дэмжих чиг үүргийн талаар мэдээлэл өглөө.

10-Р САРЫН ТОЙМ

Хойд бүсийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн уулзалт боллоо





Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөлөөс хойд бүсийн эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан уулзалт, хэлэлцүүлэг, сургалт зохион байгууллаа.

Бизнесийн тогтвортой өсөлтийн талаар хэлэлцлээ



“Тодорхойгүй орчинд тэнцвэртэй өсөх нь” панел хэлэлцүүлгээр бизнесийн эрсдэлийн удирдлага, санхүүгийн тогтвортой байдал, урт хугацааны өсөлтийн асуудлыг хөндлөө.

Эмэгтэй бизнес эрхлэгчдэд “WOMEN OWNED” тохирлын тэмдэг олголоо





“Member Care Event”–ийн үеэр эмэгтэй бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд таниулах, зах зээлийн боломжийг нэмэгдүүлэх “WOMEN OWNED” тохирлын тэмдгийг гардууллаа.

Дэлхийн мэргэжлийн болон техникийн боловсролын бага хуралд оролцлоо





БНХАУ–ын Тяньжин хотод болсон 70 гаруй улс, бүс нутгийн төлөөлөгч оролцсон олон улсын бага хуралд Монголын төлөөлөгчид оролцож, мэргэжлийн боловсрол, хүний нөөцийн хөгжлийн асуудлыг хэлэлцлээ.

Монголын ноос, ноолуурын 12 аж ахуйн нэгж “TEX+VISION KOREA 2026”–д оролцож байна





Монголын ноос, ноолуурын 12 аж ахуйн нэгж БНСУ–д зохион байгуулагдсан олон улсын нэхмэл, хувцас үйлдвэрлэлийн үзэсгэлэнд оролцлоо.

Business Outlook 2027: Ирэх оны бизнесийн төлөвийг хэлэлцлээ





“Business Outlook 2027” арга хэмжээнд бизнес, санхүү, хөрөнгө оруулалтын салбарын төлөөлөл оролцож, ирэх оны эдийн засгийн төлөв, эрсдэл, боломжийн талаар санал солилцлоо.

Шинэ гишүүддээ гэрчилгээ гардууллаа





МҮХАҮТ–ын Гүйцэтгэх захирал Ц.Магнайбаатар, Дэд захирал Ч.Баттулга нар шинээр элссэн гишүүн байгууллагуудад гэрчилгээ гардууллаа.

Бизнесийн байгууллагууд 1,400 гаруй мод тарилаа





МҮХАҮТ, Монголын Бизнесийн зөвлөл хамтран “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд бизнесийн байгууллагуудын оролцоотой мод тарих арга хэмжээ зохион байгууллаа.

“Бизнесийн түншлэлийг бэхжүүлэх нь” семинар боллоо





МҮХАҮТ, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк групп хамтран зохион байгуулсан семинарт 200 гаруй бизнес эрхлэгч оролцож, олон улсын төсөл, хөтөлбөр, тендер, худалдан авах ажиллагааны талаар мэдээлэл авлаа.

МҮХАҮТ Пусан хотын төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа



МҮХАҮТ БНСУ–ын Пусан хотын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Кан Ми Гүл тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч, хамтын ажиллагааны асуудлаар уулзлаа.


10-Р САРЫН ТОЙМ


Берлин, Хельсинки, Минск: Гурван улсад 95.5 сая ам.долларын хамтын ажиллагааны тохиролцоо хийлээ





Монгол Улсын Ерөнхийлөгчийн төрийн айлчлалын хүрээнд МҮХАҮТ-аас зохион байгуулсан Герман, Финланд, Беларусь улсын бизнес форумуудаар нийт 29 гэрээ, санамж бичиг байгуулж, 95.5 сая ам.долларын үнийн дүн бүхий тохиролцоонд хүрлээ. Монголын бизнесийн 60 гаруй төлөөлөгч оролцсон уулзалтуудаар үйлдвэрлэл, худалдаа, барилга, эрчим хүч, боловсрол, хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагааг хэлэлцэв.
















Эмэгтэй удирдах ажилтнуудын MALKIA сургалтын бүртгэл эхэллээ

Эмэгтэй удирдах ажилтнуудын манлайлал, менежментийн ур чадварыг хөгжүүлэх MALKIA олон улсын таван долоо хоногийн сургалтын бүртгэл эхэллээ.



МҮХАҮТ, Программ хангамж үйлдвэрлэгчдийн холбоо хамтран ажиллана

Талууд дижитал эдийн засаг, программ хангамжийн үйлдвэрлэл, инновац, экспорт, хиймэл оюун ухаан, өгөгдлийн эдийн засгийг хөгжүүлэх чиглэлээр санамж бичиг байгууллаа.



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ



МҮХАҮТ болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв хүртээмжтэй ажлын байр бий болгох, ажил олгогчдод мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтран ажиллана.

Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан мэдээлэл, үзэсгэлэн боллоо

Арга хэмжээгээр бизнес эрхлэгчдэд татвар, нийгмийн даатгал, төрийн дэмжлэг, санхүүжилт, экспортын боломжийн талаар мэдээлэл хүргэж, бүтээгдэхүүн, үйлчилгээний үзэсгэлэн гаргалаа.

Монголын бизнесийн төлөөлөл Канадын олон улсын үзэсгэлэнд оролцоно



МҮХАҮТ-аас анх удаа бизнесийн төлөөллийг групп болгон зохион байгуулж, Канадын Canadian Western Agribition 2026 олон улсын хөдөө аж ахуй, мал аж ахуйн үзэсгэлэнд оролцуулахаар бэлтгэж байна.



“Seoul ADR Festival 2026” арга хэмжээний хүрээнд Монголын Олон Улсын Арбитр Герман, Япон, БНСУ, Филиппин, БНХАУ, Швейцарын арбитрын байгууллагуудтай хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа.